

БАТЛАВ.

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ДАРГА



**“АВТОМАШИНГҮЙ ГУДАМЖНЫ ШИНЭ САНАА /КОНЦЕПЦИ/” БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН  
ДААЛГАВАР**

2024 он 12 сар 05 өдөр

Дугаар: ХХББАХЗ/2024020328

Улаанбаатар хот

1.	Автомашингүй гудамжны шинэ санаа /концепци/ боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;</li><li>- Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;</li><li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li><li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;</li><li>- “20 минутын хот” үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоол зөвлөмж;</li></ul>
3.	Автомашингүй гудамж төлөвлөх байршил	<ul style="list-style-type: none"><li>- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, /хавсралт-1/</li><li>- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо /хавсралт-1/</li></ul>
4.	Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"><li>- Байршил-1 /51.7га/</li><li>- Байршил- 2 /74га/</li></ul>
5.	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"><li>- Төлөвлөж буй гадна орон зайн тохижилтыг орчин үеийн хэв загвартай, тухайн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж цаашид төлөвлөх барилга байгууламжийн хэв загварын чиг хандлага, архитектуртай нь уялдуулсан төлөвлөлтийн шийдэлтэй байхаар төлөвлөх;</li><li>- Төлөвлөж буй тохижилтыг гадна орон зайн тохижилтын зураг төслийг холбогдох норм, нормативын баримт бичиг, дүрэм, журамд заасны дагуу төлөвлөсөн байх;</li><li>- Ногоон байгууламж, амралтын бүс, архитектурын жижиг элементүүд болон уран баримал, хөшөө, ландшафтын тохижилт, усан оргилуур, гадна гэрэлтүүлгийн хамтаар өвөрмөц шийдэл бүхий тохижилттой байхаар төлөвлөх;</li><li>- Төлөвлөж буй автомашингүй гудамжны тохижилтыг тухайн байршлын өндөржилттэй уялдуулан үерийн суваг, гадаргын ус зайлуулах систем төлөвлөх;</li><li>- Авто тээврийн хэрэгслийн болон унадаг дугуйн гадна зогсоол, явган хүний зам, гарц, талбайг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөж, гэнэтийн осол, онцгой байдлын нөхцөл үүссэн үед галын болон түргэн тусламжийн автомашин зорчих зам, талбайг ажиллагсдын цугларах, аюулгүй байдлаар ашиглах боломжийг хангасан байхаар төлөвлөх;</li><li>- Автомашингүй гудамж төлөвлөж буйтай холбоотой бий болох автозогсоолын ачааллыг шийдэх төлөвлөлтийн санал боловсруулах;</li><li>- Авто зам, тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарцыг холбогдох стандартын дагуу төлөвлөх;</li><li>- Гэрэлтүүлэг, авто зогсоол, цэцэрлэгжүүлэлт, орц гарцыг тухайлсан норм ба дүрмийн шаардлагыг хангуулан цогц байдлаар төлөвлөх;</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Хог цуглуулах талбай, хог цуглуулах талбай руу орох орц, хүнс тээвэрлэн нэвтрэх орц, төлөвлөх;</li> <li>- Эдийн засгийн үр ашигтай шийдлийг санал болгосон байх;</li> <li>- Тохижилтыг хүрээлэн буй орчинтой уялдуулж явган зам, дугуйн зам, авто замын тасралтгүй үргэлжлэх системийг хангаж төлөвлөх;</li> <li>- Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдлийг тусгасан байх;</li> <li>- Дэвшилтэт техник, технологи ашигласан шийдэл тусгах;</li> </ul>
6.	Зураг төслийн бүрдэл	Баримт бичгийн бүрдэл: <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын даалгавар</li> <li>- Зураглалын материал;</li> <li>- Гадаад орны жишээ, судалгаа</li> <li>- Ерөнхий төлөвлөгөө</li> <li>- Гадна тохижилт</li> <li>- Харагдах байдал</li> <li>- Танилцуулга</li> </ul>
7.	Эдийн засгийн тооцоо	- Зурагт үндэслэн урьдчилсан тооцоолол боловсруулна.
8.	Боловсруулах хугацаа	- Ажлын 10 хоног
9.	Захиалагч байгууллага	- Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа

**Хянасан:**

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ЗАХИРГАА,  
ИНЖЕНЕРИЙН ГАЗРЫН ДАРГА



Д.ЖАРГАЛ

**Боловсруулсан:**

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ЗАХИРГАА, СУДАЛГАА ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН АХЛАХ  
АРХИТЕКТОР



Ө.ЦЭРЭНБАЗАР

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

